



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 89/91

Улаанбаатар хот

Шалган туслах ажлыг зохион байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 30.3, Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гал түймэр унтраах дүрэм", Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан "Гал унтраах ангид хөтлөгдөх баримт бичгийн жагсаалт шинэчлэн батлах тухай", 2018 оны А/372 дугаар тушаалаар батлагдсан "Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах аргачлал, заавар"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой байдлын газрын бүтцийн нэгжийн албаны бэлтгэл бэлэн байдал, шуурхай ажиллагаа, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, биелэлтийг хангуулах ажлыг 2019 оны 09 дүгээр сарын 09-25-ны өдрүүдэд зохион байгуулсугай.
2. Шалган туслах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хуваарь, төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Холбогдох бүрэлдэхүүнийг бүрэн хамруулж, бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг бүтцийн нэгжийн дарга, захирагч нарт үүрэг болгосугай.
4. Шалган туслах ажлыг зохион байгуулж, дүнг 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, дэд хурандаа Н.Нямхорлоод үүрэг болгосугай.

ДАРГА,
ХУРАНДАА



Ж.ЧУДТЭМСҮРЭН

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн
4/9 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт
1117155601
УХА0038 9077073

АЛБАНЫ БЭЛТГЭЛ БЭЛЭН БАЙДАЛ, ШУУРХАЙ АЖИЛЛАГАА, АЖЛЫН
ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ДУТАГДЛЫГ АРИЛГАЖ,
БИЕЛЭЛТИЙГ ХАНГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

д/д	Ажлын хэсэг	Овог нэрс	Албан тушаал	Цол
1	Ажлын хэсгийн ахлагч	Н.Нямхорлоо	Тэргүүн дэд дарга	Дэд хурандаа
2		Д.Мөнхсайхан	Хэлтсийн дарга	Хурандаа
3	Гишүүд	Ж.Төмөрмандах	Тасгийн дарга	Хошууч
4	Гишүүд	Ж.Алтанхуяг	Ахлах мэргэжилтэн	Дэд хурандаа
5	Гишүүд	Д.Одонбаяр	Тасгийн дарга	Хошууч
6	Гишүүд	С.Содонтуяа	Ахлах мэргэжилтэн	Дэд хурандаа
7	Гишүүд	Б.Чинбат	Ахлах мэргэжилтэн	Дэд хурандаа
8	Гишүүд	Р.Мөнхбат	Ахлах мэргэжилтэн	Хошууч
9	Гишүүд	Э.Энх-Амгалан	Ахлах мэргэжилтэн	Хошууч
10	Гишүүд	Ц.Чинзориг	Ахлах мэргэжилтэн	Ахмад
11	Гишүүд	О.Мөнхбат	Мэргэжилтэн	Ахмад
12	Гишүүд	Ч.Батболд	Мэргэжилтэн	Ахмад
13	Гишүүд	Б.Сэрдамба	Мэргэжилтэн	Ахмад
14	Гишүүд	З.Мөнх-Од	Мэргэжилтэн	Ахмад
15	Гишүүд	Э.Эрдэнэбаатар	Мэргэжилтэн	Дэслэгч
16	Гишүүд	Ө.Мөнх-Отгон	Мэргэжилтэн	Дэслэгч
17	Гишүүд	Б.Анар	Мэргэжилтэн	Дэслэгч
18	Гишүүд	О.Дамдинсүрэн	Жижүүрийн байцаагч	Хошууч
19	Гишүүд	Х.Анхбаяр	Жижүүрийн байцаагч	Ахмад

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн
Х/91 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

1117155601
УХА0038 9077073

ДҮҮРГҮҮДИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСҮҮДИЙН ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ АНГИУУДЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШАЛГАН ТУСЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гал түймэр унтраах дүрэм", Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/372 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах, хэрэгжүүлэх, албаны бэлтгэл бэлэн байдал, шуурхай ажиллагаа, ажлын хариуцлагыг дээшлүүлэх хүрээнд шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, биелэлтийг хангуулахад оршино.

№	Хийгдэх ажил	Хариуцах албан тушаалтан	Хяналт тавьж ажиллах албан тушаалтан
1	Гал түймэр унтраах, аврах анги байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хуваарийн дагуу шалгах, зөрчил арилгуулах, үүрэг чиглэл өгөх, дүнг НОБГ-ын даргад танилцуулах	Хэлтсийн дарга, Ангийн захирагч	д/х Н.Нямхорлоо хур Д.Мөнхсайхан
2	Ирсэн тушаал, шийдвэр, ангийн захирагчаас гаргасан тушаал		
3	Санал, хүсэлт, ирсэн, явсан бичиг шийдвэрлэлт	Ангийн захирагч	д/ч Ө.Мөнх-Отгон
4	Албан хаагч нэг бүрийн ажлын байрны тодорхойлолт		
5	Үр дүнгийн гэрээний гүйцэтгэл, үнэлгээ		
6	Жил, хагас жил, улирал, сарын төлөвлөгөө, тайлан мэдээ, биелэлт	Ангийн захирагч, Салааны захирагч	х/ч Р.Мөнхбат
7	Цагийн бүртгэл	Ангийн захирагч	
8	Ангийн захирагчийн 7 хоногийн ажлын тэмдэглэл		
9	Соёл хүмүүжлийн арга хэмжээ		
10	Алба хаагчийн дэлгэрэнгүй бүртгэл, алба хаагч нэг бүртэй ажилласан тэмдэглэл, шийдвэрлэсэн байдал	Ангийн захирагч, Салааны захирагч	
11	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж баглуулсан байдал, хэрэгжилт, тайлан, мэдээ	Ангийн захирагч, Салааны захирагч	
12	Хичээлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан төрөл мэргэжлийн болон хууль эрх зүйн хичээл явуулсан конспект, оролцсон дүн бүртгэл - Офицер бүрэлдэхүүн - Ахлагч бүрэлдэхүүн - Энгийн алба хаагч	Ангийн захирагч, Салааны захирагч	д/х С.Содонтуяа
13	Зарлан мэдээлэх болон яаралтай цуглар дохиогоор ажилласан байдал, цугларалтын схем бүүдүүвч, халгийн тодотгол, утасны жагсаалт, дохиогоор ажиллах төлөвлөгөө	Ангийн захирагч, Салааны захирагч Оператор	х/ч Э.Энх-Амгалан

14	Сургалтын талбайн зохион байгуулалт, тохижилт, аюулгүй байдал	Ангийн захирагч	х/ч Ж.Төмөрмандах
15	Сахилга бат, ёс зүйн чиглэлээр зохиосон ажил	Ангийн захирагч, Салааны захирагч	
16	Уулзалт зохион байгуулсан бүртгэл		
17	Сайшаал, шийтгэл, жагсаалын үзлэг, хяналт шалгалт		
18	Ажлын хариуцлага алдсан алба хаагчидтай хариуцлага тооцож байгууллагад учирсан хохирлыг нөхөн төлүүлэх.		
19	Гал түймэр унтраах ангийн захирагчийн зөвлөлийн болон хамт олны хурлын тэмдэглэл, шийдвэрлэлт	Ангийн захирагч	а/х Ч.Батболд
20	Салааны захирагч нарын сар бүрийн ажил дүгнэх журам, дүгнэсэн дүн		
21	Салааны алба хаагчдын ажил дүгнэсэн үзүүлэлт		
22	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, биелэлт	Ангийн захирагч	а/х Ц.Чинзориг
23	Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажил /удирдамжит арга хэмжээ/		
24	Бие бүрэлдэхүүний албаны мэдлэг, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх талаар зохион байгуулсан ажил	Ангийн захирагч, Салааны захирагч	д/х Б.Чинбат
25	Гал түймэр унтраах, аврах зориулалтын автомашин техникийн ашиглалт, бэлэн байдал		
26	Техник хэрэгслийн ашиглалтын дэвтэр, хувийн хэрэг хөтлөлт, гэмтэл, саатлын бүртгэл, зэсээр үйлчилгээ хийж дүрмийн шаардлагын дагуу туршилт шалгалт хийсэн байдал, түүнийг хувийн хэрэг, дэвтэрт тусгасан байдал, дагалдах хэрэгсэл	Ангийн захирагч, Салааны захирагч Автын механик	а/х Б.Сэрдамба
27	Гал унтраах зориулалтын автомашин болон гал түймэр унтраах техник, багаж зэвсэглэлмжид хийгдсэн ТҮ-1, ТҮ-2, ТҮ-3 болон ХАБЭА дүрмийн шаардлагын дагуу шалгалт хийсэн тэмдэглэл, судалгаа, бүртгэл		
28	Гал түймэр унтраах, аврах ажлын техник, багаж тоног төхөөрөмжийн хадгалалт, хэмжаалалтын байдал		
29	Хүч хэрэгслийн чадварыг дээшлүүлэх талаар зохион байгуулсан ажил, арга хэмжээ	Ангийн захирагч, Азгын механик, Нярав	д/ч Э.Эрдэнэбаатар
30	Аж ахуйн няравын хэтгэлбэл зохих эрх зүйн баримт бичиг, агуулахын эмх цэгц, техник, багаж хэрэгслийн бичиг баримтын бүртгэл, судалгаа, хадгалалт, бэлтгэл бэлэн байдлыг хангах		
31	Гал унтраах 3-н шагнаы дасгал сургууль /гактик, тэрхалтын, өдөр гутмын/	Ангийн захирагч, Салааны захирагч	
32	Багаж зэвсэглэлмжид хийгдсэн бүтээлч ажил зааварчилгаа, зөвлөмж		
33	Харуулын томилолт		
34	Гал түймэр унтраах, аврах ажлын зориулалттай багаж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ашиглалт, бэлэн байдал	Ангийн захирагч, Салааны захирагч	д/х Ж.Алтанхуяг
35	Гал түймэр унтраах тооцоолол бодох аргачлал		
36	Улсын онц чухал болон галын аюултай объект, аж ахуй нэгж байгууллагад хийсэн шуурхай төлөвлөгөө, карт түүний баяжилт	Ангийн захирагч, Салааны захирагч	х/ч Д.Одонбаяр
37	Гал түймэр унтраасан тухай нотломж, нотломж бичих зааврын бүрдэл /дуудлагын хуудас, схем зураг, ярилцлага/ гал түймрийн дуудлагаар ажилласан бүртгэл		
38	Удаан хугацаагаар болон 2-оос дээш гасаг ажилласан, хүний амь нас өртсөн, их хэмжээний хохиролтой гал түймэр унтраасан тухай ярилцлага зохион байгуулсан баримт бичиг	Салааны захирагч	а/х Х.Анхбаяр
39	Гал түймэр унтраах, аврах ангийн үйлчлэх хүрээний зураг бүдүүвч, алслагдсан цэгт	Ангийн захирагч,	х/ч О.Дамдинсүрэн

	байрлах объект, айл өрхөд хүрэлцэн очих маршрут, зам гарцын судалгаа, тодотгол, орон нутгийн удирдлагад танилцуулж шийдвэрлүүлсэн байдал	Салааны захирагч	
40	Гал түймрийн онц аюултай объект 1, 2, 3-ын зам гарц, усан хангамжийн судалгаа, тодотгол хийсэн байдал		
41	Гал түймэр унтраах, аврах ангийн шифрийн болон хүчин чадлын мэдээний бүртгэл		
42	Өвөл, зуны болон бие бялдрын шалгуур үзүүлэлтээр авсан шүүлгийн материал		
43	Гал түймэр унтраах дүрэм, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн болон Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрмүүдээр авсан шалгалт, шүүлэг		
44	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн хэрэгжилт		
45	Аюулгүй ажиллагааны дүрэм, журмын хэрэгжилтийг хангасан байдал		
46	АБДТөхөөрөмжийн өрөөний хаягжилт, агааржуулалт, цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгалын бодис, материал, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн бүртгэл, техникийн үнэмлэх, хүлээлцсэн баримт, засвар үйлчилгээ хийсэн бүртгэл	Ангийн захирагч, Салааны захирагч	а/х О.Мөнхбат
	Дуудлага хүлээн авагчийн хөтөлбөл зохих баримт бичиг:		
47	- Гамшиг ослын мэдээллийн дэвтэр - Гал түймрийн дуудлагын бүртгэл - Радио дуудлагын хуваарь - Шаардлагатай утасны жагсаалт - Тайвнаа илтгэх цагийн хуваарь - Бүтээлч ажил, засвар үйлчилгээ	Ангийн захирагч, Шуурхай удирдлагын оператор	а/х З.Мөнх-Од
48	<u>Өдөр тутмын баримт бичиг:</u> - Ажлын тэмдэглэлийн дэвтэр - шуурхай дуудлагын хуудас		
49	Гал түймэр унтраах, аврах ангийн дотоод цэвэрлэгээ, их цэвэрлэгээний хузаарь гарган багтруулж тогтмол хийх	Ангийн захирагч	д/ч Б.Анар

ТАЙЛБАР: Шалган туслах ажлаар хяналт тавьж ажиллах албан тушаалтнаас бусад төв байрны офицер албан хаагч нар дүүргийн Гал түймэр унтраах, аврах ангиудын алба хаагч нарг Соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна.

АНГИ, БАЙГУУЛЛАГЫН ӨДӨР ТУТМЫН АЖЛЫГ ШАЛГАСАН ТЭМДЭГЛЭЛ

Анги байгууллагын нэр:

Салааны захирагч:

Шалгасан огноо, цаг: 2019 оны -р сарын -ны өдөр, цаг

д/д	Шалгуур үзүүлэлт	Зөрчлийн тэмдэглэл	Үнэлгээ 100 оноо
1			
2			
3			
Дундаж оноо			

Шалгасан чиглэл:

[illegible]

Өгсөн үүрэг

[illegible]

Шалгасан...../

Ажил шалгуулсан.....!